

Петро Матад: Хятадын босгон дээр газрын тосны хайгуул хийж байна

Роберт Уотерхаус

Хятадын хурдацтай хөгжлийн эрэлт хэрэгцээг хангах явдал олон тооны ашигт малтмалын компаниудын шууд болон шууд бусаар гол зорилт нь болж байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг АИМ –д бүртгэлтэй Петро Матад (МАТД) компани нь яг Хятадын босгон дээр байгаа давуу талтай бөгөөд Монголын газрын тосны үйлдвэрт хөршийн хэрэгцээ ч нөлөөлж байна. Петро Матадын гурван том хайгуулын талбайн үйл ажиллагаа, 2010 оны 4 дүгээр сард XX талбайд өрөмдлөгө хийх гэж байгаа талаар авч үзэхийн өмнө Өрнөдийн хөрөнгө оруулагчдад төдийлэн анзаарагдаагүй явж ирсэн Монголын газрын тосны үйлдвэр хэрхэн хурдан хөгжиж байгаа талаар танилцуулая.

МОНГОЛЫН ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛДВЭР: БИЗНЕС СЭРГЭЖ ЭХЛЭВ

Анхны газрын тосны занарлаг шаварыг Монголд 1922-23 онд нээсэн байна. Зөвлөлтийн хайгуул 1947 болон 1963 оны хооронд хоёр жижиг газрын тосны талбай ба 80 гүний галт уулын тогтоцыг олж илрүүлсэн ба 1947 онд нефть боловсруулах үйлдвэрийг байгуулжээ. Гэвч үйлдвэрлэл буурсан, үйлдвэрт гал гарсан, болон Баруун Сибирт томоохон хэмжээний нөөц илрүүлсэн зэрэгээс шалтгаалан 1969 онд үйлдвэрлэлийг зогсоосон байна. Зөвхөн сүүлийн жилүүдэд Засгийн газрын дэмжлэг, санаачилгын үр дүнд жинхэнэ утгаараа хөгжиж эхэлсэн; 1977 оны 6 дугаар сард Петро Матадын XX талбайн зэргэлдээ орших XIX талбайд газрын тос илэрсэн тухай мэдээ гарсан.

Монгол нь Орос, Хятадын хооронд оршдог. 20 шахуу жил чөлөөт эдийн засгийн зах зээлээр замнаж байгаа бөгөөд энэ хугацаанд парламентийн болон ерөнхийлөгчийн сонгуулийг тогтмол явуулж ирсэн. Англи болон Францийн нутаг дэвсгэрийг нийлүүлсэнтэй тэнцэх газар нутагтай, 3 орчим сая хүн амтай бөгөөд улсын экспортын нийт орлогын 80 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзлэж байна. Монгол нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн бөгөөд онд Газрын тосны тухай хуулийг баталсан; энэхүү хууль нь Ван Меурсийн зэрэглэлээр дэлхийн газрын тосны хуулиудын эхний 10-д орж байгаа бөгөөд хайгуул болон олборлолтыг хөхиүлэн дэмжихээр тоног төхөөрөмжийг гааль, нэмүү өртөг, компаний татвараас чөлөөлж, орлогын татвараас мөн чөлөөлсөн байна.

Эдгээр бүх хүчин зүйлүүд нь Монгол улсын газрын тосны салбар харьцангуй бага суурь хөрөнгө оруулалтаас хөгжлийн эхлэлий 2005 онд тавьж, өнөөдрийн байдлаар жилд 600 сая долларын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа гол нь өрөмдлөгөд суурилж ирсэн: 2008 оны 9 сар гэхэд 359 цооногийг өрөмдсөн ба тэдгээрийн 88 орчим

хувьд нь газрын тос илэрсэн байна. Дайчин газрын тосны компани \Петро Чайнагийн салбар\ ганцаараа 340 цооногийг өрөмдсөн ба үүний 207-г нь 2008 онд өрөмдсөн ба 90 гаруй хувь нь амжилттай \”газрын тосны илрэлтэй” гэж тодорхойлсон\ болсон. Хэдийгээр Монголын газрын тосны үйлдвэрлэл харьцангуй хөгжлийн эхний шатанд явж байгаа ч гэсэн “туршилтын үйлдвэрлэл” гэсэн зэрэглэлд албан ёсоор орсон ба Дайчингийн зарим нэг цооног нь Петро Матадын ХХ талбайгаас 5 орчим км-ийн зайд оршиж байна.

Петро Матадын ерөнхий менежер Б. Дэндэвчулууныг 10 дугаар сарын 21-нд Эрчим хүч, эрдэс баялагын сайд Монгол улсын дээд шагнал ЗХөдөлмөрийн гавьяаны улаан тугын одонгоор” шагнасан байна. Энэ хүн нь олон арван жилийн туршид Монгол улсын газрын тосны салбарын тэргүүлэх хүмүүсийн нэг хэмээн тооцогдож ирсэн ба компани ХХ талбайд өргөдөл гаргах асуудлыг санаачлагчдын нэг юм.

Петро Матад компаний Гүйцэтгэх захирал Дуглас МкГэй “Газрын тосны салбарт бүхий л амьдралаа зориулсан түүний гавьяаг Монголын ард түмэн ийнхүү үнэлсэнд Компаний зүгээс туйлын баяртай байна” гэж 2009 оны 10 дугаар сарын 22-нд хэлсэн байна.

НЭГ ТАЛБАЙГААС ӨРГӨЖИН ГУРВАН ТАЛБАЙД АЖИЛЛАВ

Петро Матад нь АИМ-д бүртгэгдээд 18 сар болж байгаа бөгөөд Хятадтай хил залгаа орших Монголын зүүн хилд ойролцоо орших ХХ талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээг 100 хувийн эзэмшилтэйгээр байгуулсан болно. Энэхүү том талбай нь нийт 14,250 хавтгай дөрвөлжин км газрыг хамарч байгаа бөгөөд бүртгэгдэх үед гравитиц, магнетийн судалгаа болон 2Д сейсмийн шинэ материал болон хуучин материалыг дахин боловсруулах ажлыг хийж байсан. Бүртгэгдэх үед ХХ талбайн хэсэгт 3Д сейсмийн судалгааг хийж байсан ба цуглуулсан материалуудад тайлал хийснээр өрөмдлөгө хийх газрыг товлох боломжийг компанид өгсөн юм.

Өрөмдлөгийн ажил хараахан эхлээгүй байтал, Петро Матад компани IV, V талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээг байгуулсан тухайгаа зарлаж зах зээлийг гайхшируулсан: энэ хоёр талбай нь нийт 71,000 хавтгай дөрвөлжин км талбайг хамарч байна. Энэхүү хоёр талбайг авсанаар үйл ажиллагаа ихээхэн нэмэгдсэн бөгөөд Петро Матад нь нэг акр ч талбайг ашиглахгүйгээр буцаалгүй 100% мэдэлдээ авсаар байна. Энэ бүх сайн тал нь Петро Чайна мэтийн асар том компанитай зэрэгцэн үйл ажиллагаа явуулж байгаа харьцангуй жижиг Петро Матадыг зах зээлийн капитализацийн байдлаас нь илүү томоохон тоглогч гэдгийг харуулж байна – гэхдээ хайгуулын акра талбайтай байна гэдэг мэдээж нүүрстөрөгчийг илрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн үг биш юм. Энэ гурван талбай цаашид чухам ямар өгөөжтэй байж болох талаар нарийвчилан авч үзнэ.

МАТАД-ХХ ТАЛБАЙ БА ДАВСАН ТОЛГЛОЙ

Матад-ХХ талбай нь хэтийн төлөв бүхий хэд хэдэн талбайтай бөгөөд 2008 онд тэдгээрийн 15 хэтийн төлөв бүхий талбайд үнэлгээ хийгдсэнээр дундаж “эрсдэл тооцоогүй” нөөц нь 638 сая баррель буюу амжилт олох магадлалыг нь оруулж тооцсоны үндэсэн дээр дундаж “эрсдэл тооцсон” нөөц нь 112 сая баррель болсон байна. Эдгээр тоонууд нь агуулагдаж байгаа нийт тос биш харин олборлох боломжтой гэж тооцоолсон хэмжээ юм.

Петро Матад нь эдгээр хэтийн төлөв бүхий газруудаас хамгийн их судлагдсан Давсан Толгой хэмээх талбайд 145км.кв 3 хэмжээст чичирхийллийн судалгаа хийсэн бөгөөд энэхүү судалгаа нь Давсан Толгойг өрөмдөх боломжтой болгосон. Давсан Толгой нь бүхэлдээ Их Давсан Толгой, Хойд Давсан Толгой болон Баруун Давсан Толгой гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. Эдгээр 3 хэсэг нь нийлээд “эрсдэл тооцоогүй” 147 сая баррель нөөцтэй бөгөөд “эрсдэл тооцсоны дараа” 55 сая баррель нөөцтэй юм.

Тус компани нь IPS Australasia ба ISIS Petroleum Consultants компаниудын оролцоотойгоор хурдавчилсан өрөмдлөгийн хөтөлбөр хийж мөн эерэг бүтэц, өргөгдөлөөр хаагдсан бүтэц болон налуу хагаралаар хаагдсан бүтэц гэх мэт хэтийн төлөв сайтай талбай болгох хүчин зүйлүүдийг мөн тогтоосон. Давсан Толгой дахь тусгаар эерэг бүтэц дээр компанийн анхны цооног болох DT-1-ийг өрөмдөхөөр өрөмдлөгийн Ansaí Yuehua компани сонгогдсон. Энэхүү цооног нь налуу агуулагч давхрагын хувьд өндөрлөгт байрлаж байгаа бөгөөд хамгийн ойрхон нээлтийн цооногоос 5 км зайтай. Мөн газрын тосны хайгуулын XIX талбай дахь Тосон-Уулын ордоос налуу агуулагч давхрагыг өгсөөд 10км-т байрлаж байгаа. Ажлын үр дүнгээс хамааран олгогдсон зөвшөөрлийн дагуу 5 хүртэлх цооногийг нэмж өрөмдөх болно.

Саявтархан Давсан Толгой дахь хээрийн бааз бэлэн болсон бөгөөд өрөмдлөгийн цамхаг талбайд дээр ирээд 2009 оны 11 дүгээр сарын 2-нд өрөмдөхөд бэлэн болоод байлаа. Монголын хахир хүйтэн өвлийн өмнөхөн эхлэхээр төлөвлөгдсөн богино хэмжээний өрөмдлөгийн хугацаа нь гэнэтийн цочмог хүйтрэлээс болоод хүйтэний 5 сарын турш зогссон бөгөөд 2010 оны 4 дүгээр сард цаг агаарын нөхцөл байдал сайжирмагц эхлэхээр болоод байна. 2009 онд Давсан Толгойг өрөмдөөгүй нь өрөмдлөгийг хойшлуулахаас болж газрын тос байгалийн хийн салбарт таагүй байдлыг үүсгэдэг учраас богино хугацааны хөрөнгө оруулагчидын урамыг хугалсан бол стратегийн хөрөнгө оруулагчид дараа жилийн өрөмдлөгийн ажлын үргэлжлэл ба эргэлзээ байхгүй доор дурьдах Петро Матадын саяхан эрхээ авсан хоёр талбайн хэтийн төлөвийн талаар сэтгэл догдлон хүлээж байна.

БОГД-IV БА ОНГИ-V

Зэрэгцээ оршдог, нийтдээ ойролцоогоор 71,000 км.кв талбай эзэлдэг хоёр шинэ талбайд Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ байгуулсан талаар Петро Матад саяхан мэдээлсэн билээ. Ерөнхий Гүйцэтгэх Захирал хэлэхдээ:

“Энэхүү чухал, бас том талбайнуудад эрх олж авсан явдал нь Петро Матад болон Монгол Улсын газрын тосны хайгуулын хөгжилд томоохон ахиц боллоо.” – Дуглас МакГей, 2009 оны 7 дугаар сарын 8.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Компаний үндсэн хамгийн их хувьцааг эзэмшигч нь Монголын тэргүүлэх компани болох Петровис ХХК бөгөөд Петро Матадын Гүйцэтгэх захиралын тодорхойлсоноор “ ноён нуруу ” юм \2009 оны 6 сарын 10\, Петровис саяхан өөрийн хувьцааны хэмжээг 45.88% болгон өсгөсөн \2009 оны 11 сарын 5\; энэ нь хувьцааны сангийн хувьцааны арилжааны үр дүнгийн өсөлт юм. Ийнхүү том хэмжээний байр суурь эзлэх болсоноор ИОМ хуулийн дагуу хувьцаа эзэмшигч нь тодорхой алхам хийх шаардлагатай байдаг; үүний дагуу Петровис нь компнитай байгуулсан Харилцааны гэрээгээ шинэчилж, нийт саналын хувьцааны санал өгөх эрхийг 40%-д хязгаарласан байна. Зарим нэг хөрөнгө оруулагчид компаний хувьцааны төвлөрөлд төдийлэн нааштай ханддаггүй ч гэсэн зарим нь харин эсрэгээр асуудлыг авч үздэг: хөрөнгийн хэмжээ бага, амжилтаас хувьцааны үнэ хамаарч өсдөг компаниуд нь тааламжгүй тендерүүдэд эмзэг өртөмтгөй байдаг – харин том хэмжээний хувьцаа эзэмшигч, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулсан захиралуудтай байх тохиолдолд ийм байдалд бараг ордоггүй.

САНХҮҮГИЙН БАЙДАЛ БА ДҮГНЭЛТ

Петро Матад нь одоогийн байдлаар хайгуулын үйл ажиллагаа явуулж, байгаа учраас газрын тосны худалдаанаас олох орлого гэж байхгүй; 2008 оны алдагдал нь 6.277 сая доллар байсан. Хайгуулын эхний шатанд санхүүжилтийн эх үүсвэрийг үндсэн хөрөнгийн зарим хэсгийгбарьцаалах, банкнаас зээл авах \санхүүгийн өнөөгийн нөхцөлд хүндрэлтэй\, шинээр хувьцаа гаргах замаар олж байсан.Одоогийн байдлаар компани нь өөрийн бүх талбайг 100% авч үлдэхээр шийдвэрлэж, хувьцаа гаргах замаар шаардлагатай хөрөнгийг босгосон байна.

ХХ талбайн хэмжээний тооцоо \дээр үзнэ үү\ нь тухайн талбайн цэвэр үнэ цэнийн үнэлгээг газрын тосны янз бүрийн үнэ болон үйл ажиллагааны төсөөллийг ашиглан хийх боломжийг петро Матад олгосон. Үүнээс үзэхэд, нефтийн үнэ 40-50 доллар байлаа ч гэсэн Давсан толгой эдийн засгийн хувьд ашигтай байх юм. БХГ-ний нөхцөлөөр роялти 5% ба 10% хөнгөлттэй байхад нэрлэсэн үнэ нь – 100 сая баррелийг олборлож 70 доллараар

худалдах юм гэж төсөөлөхөд – 1.4 тэрбум доллар байх юм. Нефтийг хоолойгоор дамжуулан тээвэрлэх юм гэж бодоход цооног бүр 200 бopд үйлдвэрлэх юм. Илүү консерватив байдлаар төсөөлөхөд цооног бүр 100 бopд үйлдвэрлэнэ гэж тооцоолоход Цэвэр ашигийн хэмжээ 1.2 тэрбум долларт буурах талтай. Ирээдүйн хэвтээ өрөмдлөгийн боломжит цэвэр ашиг нь одоогийн байдлаар тодорхой биш учраас цооногийн ердийн босоо өрөмдлөгийн асуудлыг авч үзэх боломжгүй байна.

Эдгээр үнэлгээнүүдээс үзэхэд компаний ирээдүйн төлөв нааштай бөгөөд энэхүү өгүүллийг бичиж байх үед зах зээлийн капитализаци 20 сая фунт байсан; одоогийн цэвэр үнэ нь 700 сая фунт гэж үзвэл энэ нь одоогийн зах зээлийн капитализацаас 35 дахинаас багагүй байна. BPS-ийн үзүүлэлт бас ач холбогдолтой; одоогийн гаргаад байгаа 125.34 сая хувьцаагаар авч үзэхэд ХХ талбайн хэмжээний тооцоо нь “эрсдэлгүй” хувьцаа бүрт 5 баррель, “эрсдэлтэй” хувьцаа бүрт 0.9 баррель ноогдож байгаа ба IV, V блокуудын хувьд асуудал тодорхой бус байна. Хувьцаа өнөөгийн байдлаар 16 пенээр худалдагдаж байна; харин ИПО-гийн үнэ үүнээс нэлээд дээгүүр байгаа ба энэ нь компаний үйл ажиллагаа сүүлийн 18 сарын хугацаанд ахицтай явагдаж, тэлж ирсэнтэй холбоотой юм.

Байгалийн нөөцийг үйлдвэрлэлд оруулахад ихээхэн хэмжээний хөрөнгө шаардлагатай байдаг нь энэ салбарын үйлдвэрлэлийн түгээмэл үзэгдэл юм. Зарим нэг E&P компаниуд энэ замаар хэзээ ч замнадаггүй бөгөөд харин илэрсэн хөрөнгийг тэр бүр арилжаалахыг эрхэмлэн үздэг байна. Петро Матадын хувьд эдгээр хувилбарыг аль нэгийг тохоон таамаглахад хэтэрхий эрт байгаа – ямар нэг газрын тос одоогоор илрүүлээгүй байгаа ч гэсэн – эдгээр гурван блокийн хувьд 1009 хувьцааг эзэмшиж байгаа нь компаний байдлыг бэхжүүлж байгаа бөгөөд энэ нь тодорхой хэмжээний талбайг эргүүлэн өглөө ч гэсэн компаний эзэмшилд ихээхэн хэмжээний хөрөнгө үлдэх талтай холбоотой юм гэдгийг бид онцлон тэмдэглэж байна. Давсан толгойд нэг цооног өрөмдөхөд компаний тооцоогоор 1 сая орчим долларын өртөг гарна; энэ нь үйлдвэрийн жишигээр маш бага хэмжээ бөгөөд товлосон цэг нь хөрсний гадагд харьцангуй ойр багаатай холбоотой юм. Энэ байдалд нь хэрэв өрөмдлөгө амжилттай болбол Давсан толгойг харьцангуй бага өртөгөөр олборлох нөхцлийг бүрэлдүүлэх талтай.

Монголын газрын тосны үйлдвэрлэл болон Петро Матадыг ихэнхи хөрөнгө оруулагчид төдийлэн мэдэхгүй байх шиг байна – ялангуяа Крдистан зэрэг газрууд анхаарлыг хэт төвлөрүүлж байна. Компанийг олон улсын хөрөнгийн зах зээлд бүртгүүлсэнээс хойшхи хугацаанд компаний үйл ажиллагаа өргөжиж, хайгуулын талбайн хэмжээ асар ихээр нэмэгдэж, өрөмдлөгийн бэлтгэл хангагдаж, өвлийн улирал дуусмагц өрөмдлөгийг эхлэхэд бэлэн болсон зэргийг авч үзэхэд Петро Матад тийм ч удаан хугацаанд хөрөнгө оруулагчдийн харааны гадна үлдэхгүйг ирээдүй харуулах биз.

Энэ өгүүллийг бичсэн автор нь Петро Матадын хувьцааг эзэмшдэг.